



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/134/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasurenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
3.1 Залруулсан алдаа	11
3.2 Залруулаагүй зөрчил.....	11
3.2.2 Албан шаардлага.....	11
3.2.3 Зөвлөмж.....	12
4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.08.24 № 01/100
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.СОЛОНГО ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон тооны хувьд байгаль орчны улсын байцаагч, хууль эрх зүйч, олон нийтийн интернэт мэдээллийн ажилтан, жижүүрийн 4 орон тоо дутуу тул 2025 оны эхэнд баталсан 1,002,925.7 мянган төгрөгийн төсвийг 76,356.4 мянган төгрөгөөр бууруулан 926,569.3 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн хүрээнд 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 870,402.3 мянган төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс аван, 856,995.3 мянган төгрөгийн зардал гаргасан байна.

Шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр батлагдсан албан хаагчдад олгох томилолтын өглөгийн 7,630.0 мянган төгрөг бүртгэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 84 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 96,7 хувиар дүгнэсэн байна.

4126020145

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	185,416,265.80	188,708,923.40
33	АВЛАГА	11,633,700.00	11,944,566.00
335	Бусад авлага	11,633,700.00	11,944,566.00
33510	Байгууллагаас авах авлага	5,650,000.00	5,650,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	5,983,700.00	6,294,566.00
35	БАРАА МАТЕРИАЛ	173,782,565.80	176,764,357.40
354	Хангамжийн материал	173,782,565.80	176,764,357.40
35410	Бичиг хэргийн материал	6,003,800.00	3,381,300.00
35420	Аж ахуйн материал	29,769,907.40	35,224,941.40
35430	Сэлбэг хэрэгсэл	111,013,226.00	108,040,726.00
35440	Түлш, шатах тослох материал	1,184,250.00	1,184,250.00
35470	Бусад хангамжийн материал	25,811,382.40	28,933,140.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,820,580,654.30	2,064,587,711.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,820,580,654.30	2,064,587,711.10
392	Биет хөрөнгө	1,733,978,654.36	1,752,964,965.28
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,166,556,574.14	2,183,009,724.14
39202	Хуримтлагдсан элэгдэл	(685,884,466.59)	(702,501,528.55)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	224,067,945.00	224,067,945.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(50,449,157.59)	(94,710,975.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	94,645,091.12	141,407,143.78
39206	Хуримтлагдсан элэгдэл	(66,575,910.67)	(47,057,135.27)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,623,371.21	72,042,503.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,411,736.82)	(28,139,656.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,600,000.00	12,600,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,193,055.44)	(7,753,055.36)
393	Биет бус хөрөнгө	86,601,999.94	311,622,745.82
39301	Програм хангамж	4,080,000.00	3,855,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,500,000.06)	(1,250,000.10)
39303	Бусад биет бус хөрөнгө	84,022,000.00	309,657,600.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(639,854.08)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,005,996,920.10	2,253,296,634.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,580,000.00	8,030,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,580,000.00	8,030,000.00
413	Өглөг	5,580,000.00	8,030,000.00
4136	Бусад өглөг	5,580,000.00	8,030,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	400,000.00	400,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	5,180,000.00	7,630,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,000,416,920.10	2,245,266,634.50
51	Засгийн газрын хувь оролцоо	2,000,416,920.10	2,245,266,634.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	719,419,322.53	719,419,322.53
51101	Өмч: - төрийн	719,419,322.53	719,419,322.53
512	Хуримтлагдсан үр дүн	1,050,441,422.36	1,310,995,902.85
51210	Өмнөх үеийн үр дүн	415,919,709.91	1,066,146,188.45
51220	Тайлант үеийн үр дүн	634,521,712.45	244,849,714.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	230,556,175.21	214,851,409.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,005,996,920.10	2,253,296,634.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,778,857,616.50	1,552,196,323.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	917,154,256.00	581,846,027.45
120	Нийтлэг татварын бус орлого	917,154,256.00	581,846,027.45
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	885,727,756.00	567,546,027.45
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	31,426,500.00	14,300,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	861,703,360.50	970,350,295.76
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,889,760.50	85,193,045.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	92,446,860.50	73,067,783.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,442,900.00	12,125,261.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	739,813,600.00	885,157,250.76
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	739,813,600.00	885,157,250.76
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,143,007,791.23	1,307,292,608.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,143,007,791.23	1,307,292,608.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,078,157,720.20	1,226,672,224.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	570,188,079.38	638,319,848.20
210101	Үндсэн цалин	322,595,279.25	354,351,485.79
210102	Нэмэгдэл	233,087,900.13	266,901,172.91
210104	Урамшуулал	14,504,900.00	17,067,189.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,853,633.38	81,218,746.49
210201	Тэтгэврийн даатгал	48,428,948.40	55,572,274.82
210202	Тэтгэмжийн даатгал	5,647,350.81	6,319,956.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,147,757.17	3,266,242.62
210204	Ажилгүйдлийн даатгал	2,762,513.52	3,202,925.49
210205	Эрүүл мэндийн даатгал	10,867,063.48	12,857,347.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,188,163.05	56,786,712.54
210301	Гэрэл, цахилгаан	4,451,569.85	8,658,456.28
210302	Түлш, халаалт	32,736,593.20	48,128,256.26
2104	Хангамж, бараа материалын зардал	114,867,720.26	56,240,060.24
210401	Бичиг хэрэг	38,280,640.00	9,778,650.00
210402	Тээвэр, шатахуун	41,476,440.00	18,650,929.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,789,981.66	2,493,229.74
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,030,000.00	2,750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,841,298.60	21,112,666.00
210408	Бараа материал акталсны зардал	5,449,360.00	1,454,585.00
2105	Нормативт зардал	800,200.00	9,228,270.00
210502	Хоол, хүнс	800,200.00	9,228,270.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	627,300.00	610,591.40
210601	Багаж, техник, хэрэгсэл	627,300.00	-
210604	Урсгал засвар	-	610,591.40
2107	Томилолт, зочны зардал	11,328,000.00	9,550,000.00
210702	Дотоод албан томилолт	11,328,000.00	9,550,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,146,757.00	3,331,026.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,002,057.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	187,110.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	88,916.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,446,700.00	-
210807	Газрын төлбөр	-	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	255,157,867.13	371,386,970.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,447,951.00	14,302,499.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	201,709,916.13	357,084,470.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	64,850,071.03	80,620,383.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,519,125.50	49,521,412.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,589,550.00	49,521,412.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,029,575.50	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,900,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	38,330,945.53	31,098,971.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,330,945.53	31,098,971.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	635,849,825.27	244,903,714.40
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,328,112.82	54,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,328,112.82	54,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,328,112.82)	(54,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	634521712.45	244,849,714.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	861,703,360.50	970,350,295.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	861,703,360.50	970,350,295.76
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,889,760.50	85,193,045.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	92,446,860.50	73,067,783.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,442,900.00	12,125,261.50
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	739,813,600.00	885,157,250.76
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	739,813,600.00	885,157,250.76
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	844,521,660.50	936,750,795.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	844,521,660.50	936,750,795.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	779,444,889.47	855,322,361.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,188,079.38	638,630,714.20
210101	Үндсэн цалин	321,595,279.25	354,662,351.79
210102	Нэмэгдэл	233,087,900.13	266,901,172.91
210104	Урамшуулал	14,504,900.00	17,067,189.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,853,633.38	81,218,746.49
210201	Тэтгэврийн даатгал	48,428,948.40	55,572,274.82
210202	Тэтгэмжийн даатгал	5,647,350.81	6,319,956.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,147,757.17	3,266,242.62
210204	Ажилгүйдлийн даатгал	2,762,513.52	3,202,925.49
210205	Эрүүл мэндийн даатгал	10,867,063.48	12,857,347.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,188,163.05	56,786,712.54
210301	Гэрэл, цахилгаан	4,451,569.85	8,658,456.28
210302	Түлш, халаалт	32,736,593.20	48,128,256.26
2104	Хангамж, бараа материалын зардал	27,360,121.66	21,556,359.24
210401	Бичиг хэрэг	2,600,000.00	3,323,400.00
210402	Тээвэр, шатахуун	19,061,040.00	11,723,629.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,199,081.66	2,493,229.74
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,400,000.00	3,676,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	100,000.00	340,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,177,250.00	13,005,841.40
210601	Багаж, техник, хэрэгсэл	977,300.00	-
210604	Урсгал засвар	5,199,950.00	13,005,841.40
2107	Томилолт, зочны зардал	6,148,000.00	7,100,000.00
210702	Дотоод албан томилолт	6,148,000.00	7,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,463,217.00	8,331,026.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,868,517.00	5,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	187,110.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	50,000.00	88,916.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,896,700.00	-
210807	Газрын төлбөр	-	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,066,425.00	28,692,962.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,066,425.00	28,692,962.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,076,771.03	81,428,433.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,745,825.50	50,329,462.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,816,250.00	50,329,462.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,029,575.50	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,900,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	38,330,945.53	31,098,971.89
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,330,945.53	31,098,971.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	17,181,700.00	33,599,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,181,700.00	33,599,500.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,181,700.00	33,599,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,181,700.00	33,599,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,181,700.00	33,599,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(17,181,700.00)	(33,599,500.00)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	719,419,322.53	230,556,175.21	415,919,709.91	1,365,895,207.65
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	719,419,322.53	230,556,175.21	415,919,709.91	1,365,895,207.65
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	634,521,712.45	634,521,712.45
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	719,419,322.53	230,556,175.21	1,050,441,422.36	2,000,416,920.10
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	719,419,322.53	230,556,175.21	1,050,441,422.36	2,000,416,920.10
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	15,704,766.09	15,704,766.09
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	719,419,322.53	230,556,175.21	1,066,146,188.45	2,016,121,686.19
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(15,704,766.09)	-	(15,704,766.09)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	244,849,714.40	244,849,714.40
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	719,419,322.53	214,851,409.12	1,310,995,902.85	2,245,266,634.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүнгээр	%
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,017,276,053.50	955,595,345.00	61,680,708.50	94%
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,017,276,053.50	955,595,345.00	61,680,708.50	94%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	90,706,753.50	85,193,045.00	5,513,708.50	94%
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	79,681,132.50	73,067,783.50	6,613,349.00	92%
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,025,621.00	12,125,261.50	-1,099,640.50	110%
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	926,569,300.00	870,402,300.00	56,167,000.00	94%

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	926,569,300.00	870,402,300.00	56,167,000.00	94%
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	906,613,900.00	870,402,300.00	36,211,600.00	96%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	906,613,900.00	870,402,300.00	36,211,600.00	96%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	854,715,900.00	806,665,833.24	48,050,066.76	94%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	597,954,700.00	568,697,672.38	29,257,027.62	95%
210101	Үндсэн цалин	357,678,000.00	353,643,604.92	4,034,395.08	99%
210102	Нэмэгдэл	209,146,700.00	198,501,377.96	10,645,322.04	95%
210104	Урамшуулал	31,130,000.00	16,552,689.50	14,577,310.50	53%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,954,400.00	72,593,989.68	(639,589.68)	101%
210201	Тэтгэврийн даатгал	48,929,300.00	49,624,895.26	(695,595.26)	101%
210202	Тэтгэмжийн даатгал	5,756,400.00	5,623,970.80	132,429.20	98%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,878,200.00	2,916,923.62	(38,723.62)	101%
210204	Ажилгүйдлийн даатгал	2,878,200.00	2,878,200.00	-	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	11,512,300.00	11,550,000.00	(37,700.00)	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,185,300.00	56,786,712.54	6,398,587.46	90%
210301	Гэрэл, цахилгаан	14,893,800.00	8,658,456.28	6,235,343.72	58%
210302	Түлш, халаалт	48,121,500.00	48,128,256.26	(6,756.26)	100%
210303	Цэвэр, бохир ус	170,000.00	-	170,000.00	0%
2104	Хангамж, бараа материалын зардал	20,128,300.00	17,858,129.24	2,270,170.76	89%
210401	Бичиг хэрэг	2,308,000.00	2,272,400.00	35,600.00	98%
210402	Тээвэр, шатахуун	9,466,600.00	9,466,399.50	200.50	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,083,700.00	2,103,229.74	(19,529.74)	101%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,850,000.00	3,676,100.00	2,173,900.00	63%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	420,000.00	340,000.00	80,000.00	81%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,100,000.00	46,605,341.40	1,494,658.60	97%
210601	Багаж, техник, хэрэгсэл	33,600,000.00	33,249,500.00	350,500.00	99%
210604	Урсгал засвар	14,500,000.00	13,355,841.40	1,144,158.60	92%
2107	Томилолт, зочны зардал	7,330,400.00	7,100,000.00	230,400.00	97%
210702	Дотоод албан томилолт	7,330,400.00	7,100,000.00	230,400.00	97%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,727,100.00	8,331,026.00	396,074.00	95%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	5,000,000.00	-	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100.00	-		
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	187,110.00	12,890.00	94%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	88,916.00	211,084.00	30%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	227,000.00	55,000.00	172,000.00	24%
210807	Газрын төлбөр	3,000,000.00	3,000,000.00	-	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,335,700.00	28,692,962.00	8,642,738.00	77%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,335,700.00	28,692,962.00	8,642,738.00	77%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,898,000.00	63,736,466.76	(11,838,466.76)	123%
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,898,000.00	50,329,462.00	1,568,538.00	97%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,898,000.00	50,329,462.00	568,538.00	99%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-	1,000,000.00	0%
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	13,407,004.76		

261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	13,407,004.76		
--------	-----------------------	---	---------------	--	--

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүнгээр	%
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	90,706,753.50	93,752,620.00	(3,045,866.50)	103%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	90,706,753.50	93,752,620.00	(3,045,866.50)	103%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	90,706,753.50	82,256,028.63	8,450,724.87	91%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	70,365,317.00	69,933,041.82	432,275.18	99%
210102	Нэмэгдэл	69,850,817.00	69,418,541.82	432,275.18	99%
210104	Урамшуулал	514,500.00	514,500.00	-	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,678,631.50	8,624,756.81	53,874.69	99%
210201	Тэтгэврийн даатгал	5,996,552.50	5,947,379.56	49,172.94	99%
210202	Тэтгэмжийн даатгал	698,526.00	695,985.76	2,540.24	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	349,319.00	349,319.00	-	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	326,887.00	324,725.49	2,161.51	99%
210205	Эрүүл мэндийн даатгал	1,307,347.00	1,307,347.00	-	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	3,698,230.00	3,698,230.00	-	100%
210401	Бичиг хэрэг	1,051,000.00	1,051,000.00	-	100%
210402	Тээвэр, шатахуун	2,257,230.00	2,257,230.00	-	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	390,000.00	390,000.00	-	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,964,575.00	-	7,964,575.00	0%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,964,575.00	-	7,964,575.00	0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	11,496,591.37	(11,496,591.37)	
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	11,496,591.37	(11,496,591.37)	
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	11,496,591.37	(11,496,591.37)	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	90,706,753.50	85,193,045.00	5,513,708.50	94%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	90,706,753.50	85,193,045.00	5,513,708.50	94%
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	79,681,132.50	73,067,783.50	6,613,349.00	92%
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,025,621.00	12,125,261.50	(1,099,640.50)	110%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг залрууллаа.Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн 16 шийдвэрийг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3.2 Залруулаагүй зөрчил

Аудитаар нийт 11,633.7 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 11,633.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс материаллаг 11,633.7 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 1,215.0 мянган төгрөгөөр бага тул "**Өөрчлөлтгүй**" дүгнэлт өглөө.

3.2.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

3.2.2 Албан шаардлага

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Өмнөх оны 11,633.7 мянган төгрөгийн авлага барагдаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" бол албан шаардлага өгөх гэж заасны дагуу шийдвэрлэв.

2. Албан үүргээ биелүүлээгүйтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Түлш, шатах тослох материалын тайланд 1,698 литр АИ92, дизель түлшийг зарлагадаа хоосон замын хуудас болон шаардах хуудас баримтад хавсаргасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13 дугаар зүйлийн 13.7-

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" , 20 дугаар зүйлийн 20.1.4-д " Ерөнхий нягтлан бодогч нь хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" бол албан шаардлага өгөх гэж заасны дагуу хариуцлага тооцох албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Харилцахын баримтад 79,748.1 мянган төгрөгийн 103 ширхэг гүйлгээний төлбөрийн хүсэлтийг анхан шатны баримтаар хавсаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" , 20 дугаар зүйлийн 20.1.4-д " Ерөнхий нягтлан бодогч нь хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "эрх ба үүрэг", "нийцсэн зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрэн хөтөлж баталгаажуулж хэвших зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 16-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны мэдээллийг иж бүрэн мэдээлээгүй	1	-	1	-			1	-				
Дүн	1	-	1	-			1	-				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Бараа материалыг анхан шатны баримтгүй зарлагдсан	1	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
Өмнөх оны 11,633.7 мянган төгрөгийн авлага барагдаагүй	1	11,633.7			1	11,633.7						
Дүн	3	11,633.7	-	-	1	11,633.7	1	-	1	-	-	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn